



БНМАУ  
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН  
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ЗАХИРАМЖ

1993 оны 08  
сарны 19 өдөр

Дугаар А/91

Улаанбаатар

хот

Төв Азийн хөгжил судлалын  
төв байгуулах тухай

1. Төв Азийн хөгжил судлал, бизнесийн төвийг Монгол Улсын  
Аж ахуйн нэгжийн хуулинд нийцүүлэн Улсын Үйлдвэрийн Газар  
хэлбэрээр байгуулсугай.

2. Төв Азийн хөгжил судлалын олон улсын төвийн дүрмийн  
санг 500,0 мянган төгрөгөөр тогтоож дүрмийг хавсралтаар ба-  
талсугай.

3. Тус төвийг Монгол улсын Аж ахуйн нэгжийн хуулийн ца-  
гуу Улсын Үйлдвэрийн Газраар бүртгэн авахыг Албан татварын  
алба /н.Сэр-Од/-нд зөвшөөрсүгэй.



ҮЙЛДВЭРИЙН ЗАСАГ  
ДЭРГ

Ц.БААСАНЖАВ



Нийслэлийн засаг даргын 1992 оны  
гүйцэтгэх захирал тоот захирамжийн хавсралт

ТӨВ АЗИЙН ХӨГЖИЛ СУДАЛГААНЫ ОЛОН УЛСЫН

ТӨВИЙН ДҮРЭМ

**Нэг. Нийтлэг үндэснэл**

I. Төв Азийн хөгжил судлалын ~~олон улсын~~ төв /Цаашид Төв гэнэ/ -ийн үндсэн зорилт нь : Төв Азийн аж ахуй эдийн засагт нөлөөлж буй олон улсын шинжтэй хүчин зүйлийг судлах, зах зээл бүрэлдэн хөгжих явцанд тодорхойлон, улс орнуудын хамтын ажиллагааг өрнүүлэх, аж ахуйн байгууллагууд бүрдэх, нэгж-мухлалуудын хоорондын хэлхээ холбоо тогтоох асуудлыг судлах, аж ахуйн хүмүүсийн амьдрал сэргэн өрнөх хөтөлбөр боловсруулах, улс орон аж ахуйн шинэ арга хэлбэрийг сонгон олоход дэмжлэг үзүүлэхэд, ирээдүйд хөгжингүй эдийн засгийн бүтэц буй болгоход нөлөө үзүүлэх бөгөөд зарим судалгаа, сургалт явуулан улсын захиалгаар ажиллах, жижиг аж ахуй эрхлэх зарчмаар өөрийнхээ орлогыг хангах болно.

2. Төв нь монгол улсын хууль тогтоомж, засгийн газрын болон нийслэлийн засаг даргын захирамж шийдвэр, энэ дүрэм болон холбогдох эрх зүйн актыг дагаж мөрднө.

3. Төв нь дүрмийн нэгдүгээр зүйлд заасан зорилтыг хэрэгжүүлэхийн тулд:

- Улаанбаатар хотын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх хэтийн ба ойр зуурын хөтөлбөр, төсөл боловсруулахад эрдэм шинжилгээний зөвөлгөө өгөх, мэдээлэлээр хангах ;

- Улаанбаатар хотын жижиг дунд аж ахуй, үйлчилгээний хөгжилд дэмжлэг үзүүлэх, эрдэм шинжилгээний судалгааны материал мэдээ-



лэлээр үйлчлэх, төв азийн бусад хотуудтай холбоо тогтоох, хот хоорондын эдийн засгийн хэлхээ холбоог хөгжүүлэхэд зуучлах ;

- зах зээлийн онол арга зүй, нийгэм эдийн засаг, эрх зүйн асуудал, зохион байгуулалт туршлагыг судлах нэгтгэн дүгнэхийн хамт төв азийн эдийн засгийн харилцаанд Улаанбаатар хотын эзлэх байр суурийг тодорхойлох, түүнийг бэхжүүлэхэд чиглэгдсэн судалгаа явуулах, зөвлөмжүүд боловсруулах ;

- олон улсын эдийн засгийн харилцааны мэдлэг эзэмшүүлэх, сургалт явуулж зөвлөгөө өгөх, эрдэм шинжилгээ сургалтын олон улсын аялал жуулчлалыг Улаанбаатар - төв азийн хотуудын хооронд зохион байгуулах ;

- Мэргэжлийн төвлөрсөн сүлжлийг Улаанбаатар хотод байгуулах төлөл боловсруулах, харагжүүлэх ажилд оролцох ;

- Улаанбаатар хот болон төв азийн бүсэд шинжлэх ухаан техникийн ололт нэвтрүүлэх, технологийн шинэчлэлт хийх, үйлдвэрлэл аж ахуйг эрхлэн хөгжихөд аж ахуйн байгууллагуудад туслах ;

- Галаад худалдааны үйл ажиллагаа, бага оврын үйлдвэрлэл эрхлэх, худалдаа санхүүгийн зууч үйл ажиллагааг явуулах болон байгаль орчинн онцлогт хүмүүсийн амьдрах нөхцлийг судлах, дорно дахины эмнэлэгийн арга нэвтрүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулж орлогоороо зарлагаа нөхөж аж ахуйн бүрэн тооцсоны үндсэн дээр бие дааж ажиллана.

- төв нь үйл ажиллагаатай холбогдон үүсэх үүргийг эд хөрөнгөөрөө хариуцана.

4. Төв нь "Удирдлагын асуудал судлах олон улсын хүрээлэн"



## 3.

/Москва дахь/ , Хөрөнгө оруулалт технологи шинэчлэлтийн банк, хөдөө аж ахуйн бирж, "Боловсрол" компани, "Монгол улсын их сургууль, Техникийн их сургууль, Бурхад улсын Сайд нарын зөвлөлийн дэрэгдэх "Уникс" фирм, Улан-Удэ хотын Дорнод сибирийн технологийн дээд сургууль зэрэг соёл шинжлэх ухаан, улсын үйлдвэр аж ахуйн байгууллагуудын санал хүсэлт, гэрээ хэлэлцээр, протоколыг үндсэлэн нийслэлийн засаг даргын тамгын газрын харьяанд засаг даргын захирамжаар ТӨВ АЗИЙН ХӨГЖИЛ СУДАЛГААНЫ ОЛОН УЛСЫН ТӨВ нэртэйгээр байгуулагдаж, дүрмийг батлан, ерөнхий захиралыг томилно.

5. Төвийг нийслэлийн засаг даргын захирамжаар өөрчилж, татан буулгана.

6. Төв нь улсын бүртгэлийн гэрчилгээ авсан өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулна.

7. Төв нь энэхүү дүрмэнд заасанаар гадна үйлдвэрлэл үйлчилгээ явуулах тохиолдолд тусгайлан эрх олгогдсон байгууллагын зөвшөөрөл авна.

8. Төв нь: Захиргааны алба, судалгаа эрдэм шинжилгээ-сургалтын тасаг, бэлчээрийн аж ахуйн байгалийн хүчин зүйл судлах тасаг, аялал жуулчлалын тасаг, худалдаа үйлчилгээний тасаг зэрэг тасгуудаас гадна төвийг өдөр тутмын удирдлагаар хангаж байх ерөнхий захирал, дэд захирал- 2, эрдэм шинжилгээ, санхүү аж ахуй хариуцсан захирал- 2 байх болно.

9. Төвийн ерөнхий захирал Монгол улсын аж ахуйн нэгжийн тухай хуулийн 42 дугаар зүйл болон төвийн эрх үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан монгол улсын хууль тогтоомж, засгийн газрын болон нийслэлийн засаг даргын захирамж шийдвэр, эрх зүйн бусад актад ний-

цүүлсэн тумаал заавар зиргана. Тумаал зааврыг төвийн ажилтан ажилчид нийт албан хаагч нар дагах мөрдөнө.

10. Төвийг байгуулсан нийслэлийн засаг дарга нь төвийн ерөнхий захиралтай тохиролцсон үндсэн дээр үндсэн санхүүгийн элэгдэл хорогдлын шимтгэлийн зарим хэсгийг төвлөрүүлэн зарцуулах эрх эдлэнэ.

11. Төвийн аж ахуй санхүүгийн үйл ажиллагааг засаг даргын дэрэгдэх эдийн засгийн цагдаагийн алба болон бусад эрх бүхий байгууллагууд хянаж шалгана.

12. Төв нь тогтоосон журмын дагуу тэмдэг албан бичгийн хэвэлмэл хуудас хэрэглэнэ.

13. Эрх бүхий байгууллага нь төвийн эрхийг хүндэтгэн сахих түүнээс эрхээ эдлэж бие даан ажиллах нөхцлийг хангах үүрэгтэй. Эрх бүхий байгууллага зөвхөн монгол улсын хууль тогтоомж, эрх зүйн бусад актад заасан эрх хэмжээний дагуу заалт өгч болно.

14. Хэрэв эрх бүхий байгууллага хууль тогтоомж зөрчсөн шийдвэр гаргасан тохиолдолд Төв нь түүнийг өөрчлүүлэх тухай саналаа уг шийдвэрийг гаргасан байгууллага буюу шүүхэд тавих болно.

15. Төв нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, монгол улсын хууль тогтоомж, засгийн газрын тогтоол, нийслэлийн засаг даргын захиралтай зөрчсөн үед монгол улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

#### Хоёр. ТӨВИН ЭРХ ҮҮРЭГ

Төв нь дор дурьдсан үүрэг хүлээнэ.

1. Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангасан бүтээгдхүүн үйлд-



вэрлэх ажил үйлчилгээ явуулна.

2. Үйлдвэрлэл үйлчилгээ явуулахдаа аюулгүй гэм хоргүй байдлыг хангана.

3. Стратегийн болон жилийн төлөвлөгөөтэй ажиллана.

4. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг хөтлөж тооцоо тайлан тэнцэлийг сар, улирал жилээр гаргах байна.

5. Экспортолсон бүтээгдхүүн болон бусад үйл ажиллагаанаас олсон валютны орлогоос, засгийн газраас тогтоосон хувь хэмжээгээр албан ханшаар улсад төгрөгөөр худалдаж байх.

6. Төрийн эд хөрөнгийг үнэгүйгээр бусдад шилжүүлэхгүй байх.

7. Ажиллагсадны эдийн засаг техникийн болон эрх зүйн мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх, давтан бэлтгэх ажлыг эрхлэн явуулах болно.

8. Хэрэглэх ухааны норм үндэслэлтэй нормативыг тогтоож мөрдөх, хөдөлмөрийг оновчтой зохин байгуулж ажиллана.

9. Материал-техникийн хангамжийн асуудлыг бие даан шийдвэрлэж үүнтэй холбогдсон норм нормативыг тогтоож мөрдөнө.

10. Бүтээгдхүүн ажил үйлчилгээнийхээ чанарын удирдлага, хяналт, сорилтыг болон туршилтын туршиг дараа тогтолцоог хангах зах зээлд өрсөлдөх чадварыг байнга дээшлүүлнэ.

Төв нь дор дурьдсан эрхийг эдлэнэ.

1. Орлого зарлага амгаас хамааран орон тоо цалингаа өөрсдөө тогтооно. Өөрийн салбар байгууллага, төлөөлөгчийн газрыг байгуулах, дүрмийг батлах.

2. Олсон орлогоороо хууль тогтоомжийн дагуу холбогдох байгууллагуудад татвар хураамж, төлбөр төлсөний дараа үлдэх мөнгийг

хөдөлмөрийн хөлс, нийгмийн хөгжлийн болон үйлдвэрлэх шинжлэх ухаан техникийг хөгжүүлэх сан болон бусад арга хэмжээнд зарцуулах.

Хөдөлмөрийн хөлсний болон нийгмийн хөгжлийн сан байгуулах хураарилах, зарцуулах журмыг хамтын гэрээнд туогаж мөрдөх.

3. Ажиллагсадын хөдөлмөрийн хөлсийг тэдний ажлын эцсийн үр дүнтэй уялдуулан нэмэгдүүлэх буюу бууруулан олгох журмыг хамтын гэрээнд тусгах тогтоох.

4. Тэтгэврийн нэмэгдэл, буцалтгүй тэтгэмж олгох нөхцөл, хэмжээ журмыг тогтоох.

5. Улсаас хатуу тогтоосоноос бусад бүтээгдхүүн, ажил үйлчилгээний үнэ тарифыг тогтоох.

6. Засгийн газраас тогтоосон журмын дагуу үндсэн сангийн элэгдэл хорогдлын шимтгэл байгуулж зарцуулах.

7. Тогтоосон журмын дагуу гаднад худалдааны үйл ажиллагаагаа бие дааж явуулах.

8. Стандартчилал, хэмжил зүйн ажлыг эрхлэж, улсын стандартчилалд хамаарагдахгүй бүтээгдхүүн, ажил үйлчилгээний холбогдолтой үйлдвэрийн стандартыг тогтоох.

9. Үйлдвэрлэлийг өргөтгөх шинэчлэх, тоноглох арга хэмжээний болон үйлдвэрлэлийн бус зориулалттай барилга байгууламжийн зураг төсвийг эрх хэмжээнийхээ дагуу манах батлах.

10. Барилга байгууламж болон технологийн дамжлагын үндсэн тоног төхөөрөмжийг өөрийн дээд байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр бусдад худалдах, шилжүүлэх, данснаас хасах.